



**“МОНГОЛ ЭКСПРЕСС” ХХК-ИЙН СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ
СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦАГААН ГОЗГОРЫН АЛТНЫ ШОРООН
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-007978 /
/Регистрийн дугаар: 5533538/

Баталсан:

БОУАӨЯ ХБОБХГ-ын Ахлах мэргэжилтэн _____ /Ц.Жаргалнэмэх/

Хянасан:

“Монгол Экспресс Эм Эн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал _____ /Ц.Баярсайхан/

Боловруулсан:

“Монгол Экспресс Эм Эн” ХХК-ийн БО-ын мэргэжилтэн _____ /Э.Намуунгэрэл/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ .ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн нэр.....	3
1.1.1. Цагаан гозгорын ордын нөөц.....	3
1.1.2. Олборлолт, баяжуулалтын хүчин чадал.....	3
1.1.3. Бүтээгдэхүүн гаргалт.....	3
1.1.4. Төслийн байршил.....	3
1.1.5. Уурхайн өнөөгийн байдал.....	4
1.1.6. Уурхайн усан хангамж.....	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	7
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....	8
3.1. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	8
3.2. Байгаль хамгаалах төлөвлөгөө.....	11
3.2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	11
3.2.2. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	12
3.3.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	13
3.3.4. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	13
3.3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	13
3.3.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	13
3.3.7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	14
3.3. Нөхөн сэргээлт дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ.....	14
3.4. 2026 оны Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө.....	15
3.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө.....	16

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ .ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Цагаан гозгор”-ын Жалга-4 хэсгийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Аж ахуй нэгжийн нэр	“Монгол Экспресс Эм Эн” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011317087
Регистрийн дугаар	5533538
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, 6/3,22 тоот
Утас	(+976) 99116225, 11-319193

1.1.1. Цагаан гозгорын ордын нөөц

“Монгол экспресс Эм Эн” ХХК-ийн захиалгаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших Цагаан гозгорын алтны шороон ордыг 1 жилийн хугацаанд олборлох ба 2 дахь жилд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, нийт төслийн үргэлжлэх хугацааг 2 жилээр авсан болно. Жилд 38.84 мян.м3 элсийг олборлон баяжуулах хүчин чадалтай байна.

1.1.2. Олборлолт, баяжуулалтын хүчин чадал


Цагаан гозгорын алтны шороон ордыг ашиглах уурхайн жилийн хүчин чадлыг захиалагч компаниас өгсөн техникийн даалгавар, ашиглах техник, тоног төхөөрөмжүүдийн хүчин чадалтай уялдуулан тооцсон бөгөөд 39.0 мян.м3 элсийг олборлон, баяжуулах хүчин чадалтайгаар ашиглахаар тогтоосон.

1.1.3. Бүтээгдэхүүн гаргалт

Цагаан гозгорын алтны шороон ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 38.84 мян.м3 элсэнд, 1,067.69 мг/м3 агуулгатай бөгөөд нийт 41.47 кг буюу химийн цэврээр 36.52 кг алтны нөөцтэй, үүнийг гравитацийн аргаар баяжуулж 89.08 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 36.94 кг шлихийн алт олборлож, химийн цэврээр 32.53 кг алтыг борлуулахаар төлөвлөөд байна.

1.1.4. Төслийн байршил

“Монгол экспресс Эм Эн” ХХК-ийн MV-007978 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун хойш 190 км, Төв аймгийн Цээл сумаас хойш 25 км-т байрлана.



Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.1.5. Уурхайн өнөөгийн байдал

Уурхайн одоогийн байдал: “Монгол экспресс Эм Эн” ХХК нь өмнө нь олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд тус уурхайд контейнер ба сэндвичэн байшин бүхий ажилчдын хотхон, тунаах болон цэвэр усны нуур, уурхайн баяжуулах төхөөрөмж хүртэл татсан 3.4 км-ийн ган хоолой бүхий 1 гүний худагтай, худгийн ЭЦВ-6 болон 8 насос

суурилуулсан. 10/0.4 кв өөрийн цахилгааны шугамтай, 250 болон 400 кВа-ийн трансформаторуудтай байна.

Уурхайн дэд бүтэц

Цагаан гозгорын алтны шороон ордыг ашиглахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цахилгаан хангамж, дулаан хангамж, хотхоны барилга, зам болон харилцаа холбоог доор тусгав. Цагаан гозгорын алтны шороон ордын уурхай нь үндсэн 5 хэсэг ба дагалдах хэсгүүдээс бүрдэнэ.

1. Төв оффис
Уурхайн удирдлагын байр
2. Ил уурхай
Ил уурхай, хөрс, элсний овоолго
3. Баяжуулах хэсэг
Угаах тоног төхөөрөмж, элсний овоолго
4. Засвар үйлчилгээ, хангамжийн хэсэг
Засварын алба, шатахуун түгээх станц, хангамжийн алба
5. Тосгон, үйлчилгээний хэсэг
Тосгон үйлчилгээний алба, эрүүл мэндийн төв, харуул хамгаалалтын алба, холбоо

Барилга байгууламж. Дараах хүснэгтэд “Монгол экспресс Эм Эн” ХХК-ийн Цагаан гозгор уурхайн барилга байгууламжууд, бүтээц эдлэл, хэмжээг тусгалаа.

Хүснэгт 4. Уурхайн барилга байгууламж

№	Байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
Хотхон				
1.	Уурхайн удирдлагын байр	м ²	56	Зөөврийн хаус
2.	Ажилчдын сууц	м ²	350	Сендвич
3.	Цайны газар	м ²	64	Зөөврийн сууц
4.	Хүнс ахуйн агуулах	ш	1	20тн контейнер
5.	Халуун ус болог угаалга	м ²	40	Зөөврийн сууц
Ил уурхай				
6.	Засварын газар, сэлбэгийн агуулах	ш	2	40тн контейнер 2ш
7.	Засварын талбай	м ²	100	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна.
8.	Түлшний ёмкост	тн	70	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна.

Уурхайн тосгон

Ажилчдын сууц. Уурхайн ажилчдын хотхоныг нэг дор 57 хүн, нөөц тооцооноор 62 хүн зэрэг байрлах хүчин чадалтайгаар төлөвлөж шаардлагатай барилга байгууламж, тавилга, эд хогшлыг тооцсон байна. Ажилчдын сууцыг 350м² талбай бүхий сендвичээр барьж байгуулан засч тохижуулан хүн амьдрах тав тухыг бүрдүүлсэн байна.

Хоолны газар. Цайны газар 40м² хэмжээтэй зөөврийн сууц байхаар засч тохижуулан хүн тав тухтай хоолох орчныг бүрдүүлсэн байна. Зөөврийн сууцанд 1 удаадаа 20-25 хүн зэрэг хооллох бөгөөд 1 хүнд дунджаар 1.55 м² талбай ноогдож байна.

Холбооны байгууламж. Уурхайн тосгонд Мобиком болон Юнителийн үүрэн телефоны сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

Түлшний агуулах. Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 21-30 хоногийн нөөц буюу 110 тонн түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

Засвар механикийн барилга байгууламж. Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын талбайд хийж гүйцэтгэнэ. Засварын талбайд дугуй засвар, гагнуур, компрессорын станц зэргийг эхний ээлжинд байгуулна.

Цахилгаан хангамж. Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Салхит Цагаан гозгор дахь “Монгол экспресс Эм Эн” ХХК-ийн 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас 10/0.4кВ-ын хүчдэлтэй 400кВа болон 250кВа-ын суурилагдсан хүчин чадалтай дэд станц угсарч уурхайг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/-ээр хангаж байна.

1.1.6. Уурхайн усан хангамж

Уурхайн ашиглалтын үед уурхайн хотхонд нэг ээлжинд буюу нэг дор 68 хүн амьдрах бөгөөд хүснэгтэд хотхоны усан хангамжийн тооцоог үзүүлэв. Хотхоны усны хэрэглээг 2015 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн БОНХАЖЯ-ны сайдын тушаалаар батлагдсан Усны хэрэглээний нормоор тооцсон.

Хүснэгт 5. Хотхоны цэвэр усны хэрэглээ

Ажиллах жил	Уурхайн ажилчдын тоо	Ажиллах хоног - дунджаар	Нэг хүний хоногийн усны хэрэглээ	Хоногт шаардлагатай усны хэрэглээ	Жилийн усны хэрэглээ	Шаардлагатай ундаргын хэмжээ
Х.нэгж	хүн	хоног	л	м ³	м ³	л/с
1 дэх жил	68	76	150	10.2	775.20	0.12
Нийт					775.20	0.12

Уурхайн хотхоны унд-ахуйн усны хэрэглээнд 0.12 л/с усны эх үүсвэр шаардлагатай байгаа ба уурхайн ашиглалтын нийт хугацаанд 0.78 мян.м³ ус хэрэглэхээр байна. Технологийн усны хэрэглээ Технологийн усны хэрэглэгч нь баяжуулах хэсэг, уурхайн зам, талбайн усалгаа болон техник, тоног төхөөрөмж байна. Баяжуулах хэсгийн усны хэрэглээг доорх хүснэгтэнд тусгалаа.

Хүснэгт 6. Зам усалгаанд шаардлагатай усны хэрэглээ

Ажиллах жил	Угаах элсний хэмжээ	1 м ³ элсийг угаахад шаардлага х технологийн ус	1 м ³ элсийг угаахад шаардлага нэмэлт цэвэр ус	Цэвэр усны хэмжээ	Хоногт шаардлагатай усны хэрэглээ	Цагт шаардлагатай усны хэрэглээ	Шаардлагатай ундаргын хэмжээ
Х.нэгж	мян.м ³	м ³	м ³	мян.м ³	м ³ /хон	м ³ /цаг	л/с
1 дэх жил	38.84	4.00	1.20	46.60	656.41	27.35	7.60
Нийт	38.84			46.60	656.41	27.35	7.60

Зам усалгаанд ашиглах усны хэрэглээнд хамгийн ихдээ 0.30 л/с усны эх үүсвэр шаардлагатай ба уурхайн ашиглалтын нийт хугацаанд 1.30 мян.м3 ус хэрэглэхээр байна. Нөхөн сэргээлтэд шаардлагатай усны хэрэглээг доорх хүснэгт харуулав.

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн усны тооцоолол

Ажлын жил	Ургамал тарих талбай	1 м ² талбай услах норм	Жилд услах давтамж	Шаардлагатай усны хэрэглээ	Шаардлагатай ундаргын хэмжээ
Х.нэгж	га	л	удаа	м ³	л/с
2 дахь жил	21.34	4.00	40.00	34,144.00	2.47
Нийт	21.34			34,144.00	2.47

Нөхөн сэргээлтэд шаардлагатай усны уурхайн ашиглалтын нийт хугацаанд 34.14 мян.м3 ус хэрэглэхээр байна. Төслийн нийт усны хэрэглээ Цагаан гозгорын алтны шороон ордыг ашиглахад шаардлагатай нийт усны хэмжээг доорх хүснэгтэнд үзүүлэв. Төслийн үргэлжлэх хугацаанд нийт 82.82 мян.м3 ус хэрэглэхээр байна.

Хүснэгт 8. Төслийн нийт усны хэрэглээ

Ажиллах жил	Шаардлагатай усны хэмжээ, м ³					Шаардлагатай ундаргын хэмжээ л/с				
	Зам усалгаа	Угаан баяжуулах хэсэг	Ногоон байгууламжийн усалгаа	Хогхон	Нийт	Зам усалгаа	Угаан баяжуулах хэсэг	Ногоон байгууламжийн усалгаа	Хогхон	Нийт
1 дэх жил	1,300.00	46,604.84		775.20	48,680.04	0.30	7.60		0.12	8.02
2 дахь жил			34,144.00		34,144.00			2.47		2.47
Нийт	1,300.00	46,604.84	34,144.00	775.20	82,824.04	0.30	7.60	2.47	0.12	8.02

Төслийн усны төлбөр Цагаан гозгорын алтны шороон ордыг ашиглах уурхай нь Орхон голын сав газрын гүний усанд хамаарагдах бөгөөд Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолын 1, 2-р хавсралтын дагуу ундны усны үнэ төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа ба технологийн усны үнэ 2,076.90 төг/м3, ногоон байгууламжийн усалгааны усны үнэ 98.90 төг/м3 байхаар тооцлоо.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Цагаан гозгор”-ын Жалга-4 хэсгийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг Монгол Улсын Засгийн Газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014 оны 04-р сард А-117 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэв. Мөн нөлөөллийн оноот үнэлгээний аргыг ашиглан нөлөөллийн үр дагавар, түүнд өртөх нутаг дэвсгэр болон байгаль орчны чадамжид оноо өгч дүгнэлт гаргав. Шалгуур онооны үзүүлэлтийг дараах байдлаар авч үзэв. Үүнд:

Хүснэгт 9. Нөлөөллийн үзүүлэлт ба оноо

Тэмдэглэгээ	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт	Нөлөөллийг үнэлэх оноо		
		Эерэг (1)	Сөрөг (-1)	Нөлөөгүй (0)
Н	Нөлөөлөл	Их (3)	Дунд (2)	Хязгаарлагдмал (1)
А1	Байгаль орчны сүйрэл	Их (3)	Дунд (2)	Бага (1)
А2	Байгалийн нөөц, орчны чанарт учруулах нөлөө	Их (3)	Дунд (2)	Бага (1)
А3	Тохиолдол магадлал	Их	Магадлалтай	Магадлал бага
В1	Нөлөөллийн хамрах хүрээ	Бүсийн	Орон нутгийн	Маш бага талбайд
В2	Үргэлжлэх хугацаа	Урт	Дунд	Богино
С1	Нөхөн сэргээгдэх чадвар	Үл сэргээгдэх	Хэсэгчлэн сэргээгдэх	Бүрэн сэргээгдэх

(А1).- Байгаль орчны сүйрэл

(А2)- Байгалийн нөөц ба хүрээлэн буй орчны чанарт үзүүлэх нөлөө

(А3)- Янз бүрийн тохиолдол

Үр нөлөөний хамрах хүрээ

(В1)- Орон зайгаар

(В2)-Үргэлжлэх хугацаагаар

Сөрөг нөлөөллийг даах байгалийн чадавхи

(С1)-Нөхөн сэргээгдэх байдал

(Н)-Нөлөөллийг эерэг, сөрөг ба нөлөөлөлгүй гэсэн ангиллаар авч үзнэ.

Нөлөөллийн үзүүлэлт ба оноог хүснэгтэд, нөлөөллийн зэргийн шалгуурыг 2.2-р хүснэгтэд тус тус харуулав.

Нийлбэр нөлөөллийн зэргийг $N \cdot (A1+A2+A3+B1+B2+C1)$ томъёогоор илэрхийлэв.

Хүснэгт 10. Нөлөөллийн зэргийн үнэлэмж

Сөрөг нөлөөлөл		Эерэг нөлөөлөл	
Их	<-15	Их	+15<
Дунд	(-15,-9)	Дунд	(+9,+15)
Бага буюу нөлөөгүй	-9<	Бага	<+9

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бүрийн хамрах цар хүрээ болон тохиолдох магадлал хир байгааг өгөгдөл цуглуулах болон өгөгдөлдөө задлан шинжилгээ өгөх замаар

экпертүүд дор бүрнээ шинжилсэн. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг байгаль орчны өнөөгийн төлөв байдлын суурь судалгааны үндсэн дээр оноот арга болон үнэлгээний шалгуурын дагуу өгөгдөлд дүн шинжилгээ хийв.

Хүснэгт 11. Уур амьсгалын хүчин зүйлээс үүсэх нөлөөлөл

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн онооны үзүүлэлт							Нөлөөллийн түвшин	
		Н	А1	А2	А3	В1	В2	С		Σ
1	12 цаг 7 мм-ээс их цас, 15мм-ээс их бороо орвол алсын барааны харагдацыг буруулан зам талбайг хааж, эвдэн, ажлын цагийг алдагдуулах мөн түүнчлэн уурхайн машин механизмуудын үйл ажиллагаанд хүндрэл учруулна.	-1	1	1	2	2	2	1	-9	Бага
2	Олборлолт явуулах зарим хэсэг, орчимд хүйтэн улирал сублимаци болон мөстлөг илүүтэй үүсэх	-1	1	1	1	1	2	2	-8	Бага
3	Шаварлаг хөрс 35см, бор хөрс 25-28 см, хар шороон 16-18см, тосорхог элсэн хөрс 27см гүнд чийгээр ханавал машин сууж мөн түүнчлэн уурхайн ажилд хүндрэл учруулна.	-1	2	2	2	2	2	2	-12	Дунд
4	Салхины хурд 15м/с-ээс дээш болсон болон манантай үед алсын барааны харагдац буурч зам талбайг харахад хүндрэл учруулан ажлын цагийг алдагдуулж зарим тохиолдолд осолд хүргэнэ.	-1	2	2	2	2	2	2	-12	Дунд
Дүгнэлт		Дээр дурьдсан нөлөөллүүд 50% дунд 50% нь бага нөлөөлөлтэй байна. Тус төслөөс микро уур амьсгал, мезо-уур амьсгалд үзүүлэх нөлөөллийг дунд зэргийн нөлөөтэй гэж үзэв.								

Хүснэгт 12. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

№	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийн онооны үзүүлэлт							Нөлөөллийн түвшин	
		Н	А1	А2	А3	В1	В2	С		Σ
1	Уулын ажлын явцад үзүүлэх тоос	-1	2	3	3	1	1	2	-12	Их
2	Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт	-1	2	3	3	1	1	2	-12	Их
3	Бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас хийсэх тоос шороо	-1	2	1	2	1	3	1	-10	Дунд
4	Хөрсний овоолго үүсгэснээс гарах тоос	-1	2	2	2	1	2	1	-12	Дунд
5	Машин механизмын дуу чимээ	-1	2	1	3	2	2	2	-12	Их
6	Уурхайн механизмуудын яндангаас ялгарах хорт хий, уурын зуухнаас ялгарах хорт хий	-1	2	1	2	2	2	1	-10	Дунд
Дүгнэлт		Нийт нөлөөллийн 50% нь дунд, 50% нь их гэсэн ангилалд багтаж байгаа нь алтны уурхайн төслөөс								

	тухайн нутгийн агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн зэргийг ИХ гэж дүгнэж байна.
--	---

Хүснэгт 13. Газрын гадарга хэвлийд үзүүлэх нөлөөлөл

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн онооны үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
		Н	А1	А2	А3	В1	В2	С1	Σ	
1	Газрын нөөц багасах	-1	2	2	2	2	2	2	-12	Дунд
2	Ач холбогдолгүй чулуулгаар бүрхэгдсэн талбай үүсэх	-1	2	2	2	1	2	2	-10	Дунд
3	Огцом хэлбэр бүхий гадаргуу үүсэх	-1	2	2	2	1	2	2	-10	Дунд
4	Үүсмэл ландшафт	-1	2	2	2	1	2	2	-10	Дунд
5	Газрын гадаргын хэв шинжийн өөрчлөлт	-1	2	2	-1	2	2	2	-10	Дунд
6	Газрын хэвлийд хоосон орон зай үүсэх	-1	2	1	1	2	2	1	-9	Бага
	Дүгнэлт	Дээрх нөлөөллүүдийг бууруулах юмуу арилгах аргагүй тул дунд гэсэн ангилалд орж байна. Гэхдээ энэхүү нөлөөллийг хамрах хүрээ нь тухайн заасан хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд төсөл дууссан хойно тус газрыг нөхөн сэргээх, эргэн тохижуулах боломжтой тул нөлөөлөл харьцангуй бага гэж үзнэ. Дээрх дурьдсан нөлөөллүүдийг 16,7% бага, 66,8% нь дунд сөрөг нөлөөлөлтэй.								

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хуулийн 9-р зүйлд зааснаар Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг юм.

“Монгол экспресс Эм Эн” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Цагаан гозгор”-ын Жалга-4 хэсгийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2026-2027 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХАЖ Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу “Би Гуру Консалтинг” ХХК боловсруулав.

Хүснэгт 9. БОМТ-ий задаргаа /2026-2027/

№	Ажлы нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль хамгаалах төлөвлөгөөний зардал	54 300.0
2	Нөхөн сэргээлтийн нийт зардал	440 000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	50 000.0
4	Байгаль орчны хяналт-шинжилээний хөтөлбөр	7 000.0
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	551 300.0

3.2. Байгаль хамгаалах төлөвлөгөө

3.2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Хүснэгт 10. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэх ажил	Зардал
1	Уурхайд ашиглаж байгаа машин техникийн хөдөлгөөн, хөрс хуулалт хийх, шимт болон шимэрхэг хөрсний овоолго, дотоод тээврийн зам зэргээс үүсэх тоосжилт	Уурхайлалтын үйл ажиллагааны үед хуурайшилттай байх тохиолдолд усалгааг тогтмол хийх	Усалгааны зардал оруулав.
		Шатах тослох материал хадгалах сав, машин механизмуудын хорт хий ялгаруулалтанд хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол хийж, хорт хийн ялгаралтыг стандарт түвшинд барьж ажиллах	500 0
2	Машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, шатах тослох материалын ууршилт, ажилчдын суурингаас бохирдуулагч бодис агаарт тархах	Ашиглагдаж буй замын дагуу тэмдэг тэмдэглэгээ тавих, олон салаа зам гаргахгүй байхаар ажилчидад үүрэг чиглэл өгч, хурдны хязгаарыг мөрдөж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих.	Үйл ажиллагааны зардал оруулав.
		Уурхайн техник, тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааг шалгаж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх.	Үйл ажиллагааны зардал оруулав.
		Машин техникийн тос тосолгооны материалын хог хаягдлыг цуглуулан ангилан ялгаж зориулалтын цэгт хүргэх.	Үйл ажиллагааны зардал оруулав.
Нийт			500.0

3.2.2. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 11. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Зардал
		Ахуйн бохир ус зайлуулах цооногийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах.	Үйл ажиллагааны зардал

1	Төслийн үйл ажиллагааны улмаас гүний усанд бохирдол үүсэх, гүний усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Цэвэрлэх байгууламжийн оролт гаралтын уснаас дээж авах.	Үйл ажиллагааны зардалд
		Цэвэрлэх байгууламжийн шүүгч хэсгийг солих умбуурын бодисыг зөвшөөрөгдөх хэмжээнд барих.	1,000.0
		Унд-ахуйн хэрэглээнд ашиглагдаж буй гүний худгийн усыг ОХШХ-ийн дагуу шинжилгээ хийлгэх	200.0 ҮА зардалд
Нийт			1200.0

3.2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 12. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Зардал
1	Уурхайн олборлолтын улмаас хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөх, тэмдэг тэмдэглэгээ хангалттай байрлуулаагүйгээс төлөвлөлтөөс гадуур олон салаа зам үүсэх	Уурхайн зам болон олборлолтын хэсгийн тэмдэг тэмдэглэгээг засаж сайжруулах, замын тэмдгийн нөөц бүрдүүлэх.	Үйл ажиллагааны зардалд
		ШТМ-ын хадгалах хэсэг болон автомашины засварын төвийг бүрэн ашиглалтанд оруулах.	Үйл ажиллагааны зардалд
		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад анхааруулж, төлөвлөгөөний дагуу зам гаргаж ашиглуулах.	Үйл ажиллагааны зардалд
2	Машин техникийн тос тосолгооны материал, шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүн асгаралтаас хөрс бохирдох	ШТС-ын хэсгийг засаж тохижуулан, суурийг хатуу хучилттай болгох, галын аюулаас хамгаалах багаж хэрэгсэл байршуулан хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн олдсан тохиодолд ашиглах шингээгч материал бэлэн байлгах.	450.0
		Цэнэглэгч машинуудын зогсоол байгуулж, ашиглалтыг сайжруулах.	
	Уурхайн гал тогоо, угаалга цэвэрлэгээнээс гарах бохир ус нь хөрсний бохирдол үүсгэх	Бохирын цооногийн засвар үйлчилгээг тогтмол хийж, төлөвлөгөөт хугацаанд шинжилгээ хийлгэх.	1,000.0
Нийт			1450.0

3.2.4. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Зардал
---	--------------------------	-------------	--------

1	Хөрсний үе давхарга холилдон, гадарга дээр хөрс үүсгэгч эх чулуулгууд ил гарах	Уурхайн малталтыг дүүргэж, тэгшлэх, шимт хөрсөөр талбайг хучих, тэгшилсэн талбай дээр дэвссэн хөрсний үеийг тэгшлэх, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх боломжоор хангах	Үйл ажиллагааны зардал
		Шимт хөрсний овоолгын шинж чанарыг алдагдуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал

3.2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Зардал
1	Уурхайлалтын шууд нөлөөллөөр байгалийн ургамалжил устгах	Уурхайлалтын явцад олон тооны машин техник ажиллах тул тэдгээрийн хөдөлгөөний чиглэл явах маршрутыг нарийн төлөвлөн, салаа зам үүсгэхгүй байхыг анхааруулаж, жолооч ажилчдад байгаль орчинтой зөв харьцах, хамгаалах чиглэлээр заавар зөвлөгөө өгч сургалт явуулж, хяналт тавих;	500,0
		Уурхайн кемпэд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, усан оргилуурыг шинэчилэн засварлаж тохижилт хийх.	500,0
		Нарийн ногооны хүлэмж байгуулах /32x8 метр/	
Нийт			1000.0

3.2.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хийх арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Зардал
1	Хог хаягдлын бүртгэлийг бий болгох	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгах ажлыг тогтмол хийх	350.0
		Аюултай хог хаягдал болох ажилласан тос масло түр хадгалах сав болон аккумуляторыг тусгайлан хэсэгт хадгалж гэрээний дагуу зайлуулах, бүртгэлжүүлэх ажлыг хэрэгжүүлэх	
		Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулж цэгт нийлүүлэх	-
2	Ахуйн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын цэг дээр хадгалаагүйн улмаас хөрс, гүний ус, агаар, ургамал, амьтан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилж хаях, хог хаягдлын цэгийг хаягжуулах, шаардлагатай бол нэмэлт засвар үйлчилгээг хийх.	250.0
		Уурхайд үүссэн хог хаягдлыг сумын хогийн цэгт өөрийн техникээр тухай бүрт нь хүргэх.	960.0
		Дахивар хог хаягдлыг прэслэгч машин худалдан авч ашиглах.	2,200.0

	Хоёрдогч түүхий эд болох шил, лааз, хуванцар савыг түүхий эдийн төвд хүргэн тушаах.	500.0
	Сумын ЗДТГ-тай байгуулсан хог хаягдлын гэрээний төлбөрийг төлөх.	600.0
	Хог хаягдлын менежментийн сургалт зохион байгуулах	Дотоод нөөц
Нийт		4,860.0

3.2.7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалахад удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг боловсронгуй болгох, энэ чиглэлээр үүрэг хариуцлагыг сайжруулах дотоод журам тогтоож мөрдөх, шинэчлэн сайжруулах, байгаль орчны асуудал хариуцсан ажилтаны үүрэг хариуцлагыг тодорхой болгох.	Дотоод төлөвлөлт
2	Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдлийг илрүүлэх, хөдөлмөр хамгаалалын журмыг нягт мөрдүүлэх, болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг тодотгож ажиллах.	Дотоод төлөвлөлт
3	Байгаль орчин, аюулгүй ажиллагааны хяналт шалгалтыг төлөвлөгөө, хуваарын дагуу хийж хэвших, ажилтнуудад энэ чиглэлийн мэдээллийг тогтмол өгөх.	Дотоод төлөвлөлт
4	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр болон гал түймэр, усны аюул зэрэг гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран 2-оос доошгүй удаа зохион байгуулах.	400.0
5	Орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг сонсож хариу өгөх.	Дотоод төлөвлөлт
6	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр зохион байгуулах төлөвлөгөөт ажлууд /үер усны аюулаас хамгаалах суваг шуудуу даланг сэргээн шинэчлэх/	3,000.0
Нийт		3,400.0

3.3. Нөхөн сэргээлт дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ

Хүснэгт 14. Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

№	Хийж гүйцэтгэх ажлууд	Зардал
1	Бурхантай хөндийд тарьсан 2500 ширхэг модны усалгаа арчилгааг хийж, ургалтын явцын тооллого хийж, нөхөн тарилт хийх.	5,000.0
2	Салхитын баригадаас уурхай хүртэлх цахилгааны шонгуудад шонхор шувууны үүр засч шувуу хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.	10,000.0
3	Чулуутад нутагшуулсан тарваганы тоо толгойг нэмэгдүүлэх, хамгаалах талаар Сумын Байгаль	1,200.0

	хамгаалагч болон тухайн газрын нөхөрлөлийн гишүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах.	
4	Тарваганы тооллогыг Хустайн байгалийн цогцолборт газрын захиргаатай хамтран хавар, намарт тус тус зохион байгуулах.	10,000.0
4	Техникийн нөхөн сэргээлтийг 2 га талбайд хийж хүлээлгэн өгөх.	Үйл ажиллагааны зардалд
5	Биологийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран 1,2 га талбайд хийх.	12,000.0

3.4. 2026 оны Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. 2026 оны БОМТ-ний дагуу хийх ажлын зардлын нэгдсэн тооцоо

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Зардал мян.төг
1	Агаар мандалд учруулсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	500 000
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	1 200 000
3	Хөрсөн бүрхэвчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	1 450 000
4	Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	1 000 000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	4 860 000
6	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний зардал	3 400 000
7	Нөхөн сэргээлтийн зардал	-
8	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлтийн зардал	26 200 000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 500 000
	Нийт	40 300 000

3.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө

“Монгол Экспрес Эм Эн ” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Цагаан гозгор”-ын Жалга-4 хэсгийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн БОННУ-ний тайлан, БОХТ-т тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт хийж ажиллана.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Хяналт шинжилгээний ажил
1	Агаар	Төслийн талбай орчмын агаарын чанар Хяналтын цэгүүд: нийт 4 цэгт Тоос: - Уурхайн карьерийн ойр орчимд /1цэгт/ - Угаан баяжуулах талбайн орчимд /1 цэгт/ - Ажилчдын суурингийн ойр орчимд /1 цэгт/
2		Гадаргын ба гүний усны чанар Хянах зүйл: Гидрохими, хүнд металл, хатуулаг /рН/

	Гадаргын болон гүний ус	Хяналтын цэгүүд: нийт 2 цэгт <ul style="list-style-type: none"> - Гидрогеологийн хяналтын цэгт /1 цэгт/ - Уст цэгийн ойр орчмоос /1 цэгт/ Цэвэрлэх байгууламжийн уснаас оролт гаралтын дээж авах
3	Хөрс	Хөрсний үржил шимийн өөрчлөлт Хянах зүйл: - Хөрсний бохирдлыг тогтоох, Хяналтын цэгүүд: <ul style="list-style-type: none"> - Уурхайн орчмын зам, талбай орчимд, - Шатахуун түгээх станцын ойролцоо, - Авто зогсоол, - Шатах тослох материалын агуулах орчимд
5	Амьтны аймаг	Амьтны тархац, төрөл зүйл, тоо толгойд үзүүлэх нөлөөлөл: Хянах зүйл: <ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн малын тэжээлийн хомсдол - Чимээ шуугиан - Суурьшил, хөдөлгөөн - Хулгайн агналтаас үзүүлэх нөлөөлөл Хяналтын цэгүүд: Уурхайн талбайн ойр орчимд
Нийт зардал		1 500 000

Хавсралт

УБ-2 Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 21 дугаар тусгайгаар баталсан



МОНГОЛ УЛС

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000026610

2011.11.16 <i>/ Бүртгэсэн өдөр, өдөр /</i>	9011317087 <i>/ Улсын бүртгэлийн дугаар /</i>	
	5533538 <i>/ Хувьцагчийн дугаар /</i>	
Монгол экспресс Эм Эн	Хэлтэрлэгдмэл корпоративтай компани	
<i>/ Хуулийн этгээдийн нэр, хөгжүүлэлийн хэлбэр /</i>		
Дүрэм <i>/ Тусгай байгууллын баримат бичиг /</i>		
Шийдвэр <i>/ Хувьцаагийн нэр /</i>	01 <i>/ Дугаар /</i>	2011.11.09 <i>/ Огноо, өдөр /</i>

511001	Хувьцаагийн гүйцэтгэл <i>/ Хувьцаагийн гүйцэтгэл /</i>
512200	Хүнд, барууны бөөний болон жижиглэнгийн худалдаа
511200	Газар тариалан эрхлэх
511000	Газар худалдаа
751300	Ажлын зүүнчлэл

Хугацаагүй	1	30700.0
<i>/ Хугацаа /</i>	<i>/ Хувьцаагийн нэр /</i>	<i>/ Хувьцаагийн үнэ, хэмжээ, хэмжээ, хэмжээ /</i>

Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 6-р хороолол, 34 - 22 тоот, утас: 3310190, утас: 3310192
/ Хуулийн этгээдийн дэлгэц болон хэргийн хэргийн /



Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн
 этгээдийн бүртгэлийн газар
/ Бүртгэсэн, бүртгэсэн /


Хариуцах дансны бүртгэл

Хариуцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан рэнэдэг
Хувалдаа хэргийн банк	Төдөлгөй	409030275	М.Батсайхан

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлттэй бүртгэл

Д/а	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэл	
		Огноо	Ажилтан гэмдэг
2	Минхонгор овогтой Адьяасүрэн-е Гүйцэтгэх захирал-р томилсон-ыг бүртгэж	2015.09.22	О.Шажиртуяа
3	Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, оддын хотхон цогцолбор, 37 а, 6 тоот Утас1: 79014805, Утас2: Факс: хаягийг шинээр бүртгэж	2015.09.22	О.Шажиртуяа
3	Хувьцаа эзэмшигч 6 нэмэгдэж 0 хэсэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 7 болж өөрчлөгдсөнийг бүртгэж.	2022.04.04	О.Шажиртуяа
4	Хуралбаатар овогтой Бадрах-е Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэж.	2022.04.04	О.Шажиртуяа
5	Мавсар овогтой Ариунзэрал-е Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэж.	2022.04.13	О.Шажиртуяа
6	4610 Хувалдааны зуучлагч үйл ажиллагааг хэсэнийг бүртгэж. 46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөмжүй хувалдаа үйл ажиллагааг шинээр бүртгэж.	2022.04.13	О.Шажиртуяа
7	Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, оддын хотхон цогцолбор, 37а, 6 тоот Утас1: 99116225, Утас2: 11319193, Факс: хаягийг шинээр бүртгэж.	2022.05.06	О.Шажиртуяа
8	Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, 5 хороолол, 5/3, 21 тоот Утас1: 99116225, Утас2: 11319193, Факс: хаягийг шинээр бүртгэж.	2022.05.06	О.Шажиртуяа
9	Цэндонор овогтой Баярсайхан-е Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэж.	УТХ: 2022.07.21 99116225 11319193	О.Шажиртуяа
10	08990 Ашигт малтмал ашиглах /2007.02.09-2037.02.09/ үйл ажиллагааг шинээр бүртгэж.	2022.08.08	О.Шажиртуяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцаага хүлээлгэнэ.
 Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛААЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 7978А

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар
зүйлийг үндэслэн

_____ *Сэлэнгэ* _____ аймаг /хот/-ийн
_____ *Орхонтууа* _____ сум /дүүрэг/-ын
_____ *Цагаан гозгор* _____ нэртэй газарт орших
_____ 232 _____ гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд
заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг
зовшоорч улсын бүртгэлийн _____ 23/82 _____ тоот гэрчилгээтэй
_____ *Бургай Н.Н.К* _____ -д
энэхүү тусгай зөвшөөрлийг _____ 30 _____ жилийн
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА _____ Л. БОЛД

2007 оны 02 сарын 09 өдөр

Улаанбаатар хот



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРНИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2022 оны 06 дугаар сарын 03

№ ХХ-09-08

Улаанбаатар хот

*Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших
Цагаан гозгорын алтны шороон ордын Жалга-4 хэсэг дэх
хайгуулын 0-IX шугамуудын хоорондох эртний
гольдролд 2021 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын
үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай*

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших Цагаан гозгорын алтны шороон ордын Жалга-4 хэсэг дэх хайгуулын 0-IX шугамуудын хоорондох эртний гольдролд 2021 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгээр геологич С.Мөнхбадрах, Д.Ганбат нарын боловеруулсан тайлан, уг тайланд дахь ордын нөөцийн тооцоонд МУ-ын зөвлөх геологич Б.Жаргалсайханы хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших 232 га талбай бүхий Цагаан гозгор нэртэй ашигт малтмалын MV-007978 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2007 оны 02 дугаар сарын 09-ний өдөр “Хурай” ХХК-д анх олгосон байна.

Тус талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 190 км-т, Төв аймгийн Цээл сумын төвөөс хойш 25 км, Хөтөл хотхоноос урагш 60 км, Орхонтуул сумаас зүүн урагш 40 км-т тус тус оршино.

2. “Хурай” ХХК нь тусгай зөвшөөрлийн талбайд 2021 онд геологи, хайгуулын ажлыг гүйцэтгэж, алтны шороон ордын геологийн нөөцийг бодитой болон боломжтой зэрэглэлээр тогтоож, хайгуулын ажилд нийт 350.5 сая төгрөг зарцуулсан байна.

3. Тус ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн өмнөд хэсэгт 1998–1999 онуудад хайгуулын ажлыг Ж.Тогтох, Т.Семейхан нар удирдан хийж, үр дүнгийн тайлан бичсэнээр C_1+C_2 зэрэглэлээр (баруун хэсэг 361.27 кг, зүүн хэсэг 78.22 кг) химийн цэврээр 439.49 кг алтны нөөц бүртгүүлсэн байдаг.

Түүнчлэн 2008–2009 онуудад геологч Ж.Баярхүү нар ашигт малтмалын MV-007978 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн Жалга-4 хэсэгт орчин үеийн гольдрол ба түүний доор байрлах Неогены улаан шаврын уланд орших эртний гольдролын хэмжээнд хайгуулын X-XIII дугаар шугам хооронд нөөц бодож, химийн цэврээр 42.21 кг алтны нөөц бүртгүүлэн олборлолт хийсэн байна.

“Хурай” ХХК нь дээрх тусгай зөвшөөрлийн талбайд 2007 оноос ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлж 2014 оныг дуустал хугацаанд явуулсан ба талбайн өмнөд хэсэгт 2000

онд бүртгүүлсэн нөөцөөс 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 6.1 кг алтны
(хими цэврээр) нөөцийн үлдэгдэлтэй байна.

4. “Хурай” ХХК нь 2021 онд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлаар 52 цооног
буюу 1828.6 тууш.м өрөмдлөгийн ажил, 439 ширхэг сорьц авч угаан боловсруулж, 2.77
км² талбайд байр зүйн зураглалын ажлыг тус тус хийжээ.

Технологийн туршилтын ажлыг 2009 онд Геологийн төв лабораторит хийсэн бөгөөд
Археологийн судалгааг 2011 онд МУИС-ийн Археологи-Антроплогийн тэнхим
гүйцэтгэсэн байна.

5. Цагаан Гозгорын ордын талбайн дүүрэг нь Монгол орны хойд хэсэгт, зүүн-хойш
сунан орших Хэнтийн нурууны хойд биед Орхон голын хөндийн урдтай байрлахдаа
тектоник мөчлөгийн Каледонид структурыг бүрдүүлэгч дунд кембри – доод ордовикийн
хараа формацийн шельфийн үүсэлтэй терриген чулуулаг ба түүнийг урсан дунд – хожуу
ордовикийн бороо бүрдлийн синколлизын гаралтай ороген үүсэлтэй гранитойд чулуулгийн
байршлаар геологийн суурь тогтоц илэрхийлэгдэнэ.

2021 онд нэмэлт хайгуулын ажил хийгдсэн хэсэгт уртаашаа 800 м, өргөн нь
дунджаар 40 м урсац хэлбэрээр сунаж тогтсон 44.9 гүнд 2.26 м элсний давхаргад 1433.55
мг/м³ дундаж агуулгатай 74.48 кг алтны нөөц тогтоосон байна. Ордыг III бүлэгт
хамааруулжээ.


6. Жалга-4 ордыг төлөөлүүлэн 2009 онд хийсэн технологийн туршилт дахь
мөхлөгийн шинжилгээгээр ашигт давхаргын дийлэнх буюу 18.34 %-д нь >10 мм
хэмжээтэй, 12.67 %-д нь >1.125 мм хэмжээтэй хэсгүүд тус тус эзэлж байгаа нь
тогтоогдсон. Харин тус ордын хайгуулын шугам тус бүрийн дээжийг нэгтгэн шигшүүрийн
шинжилгээ хийхэд алт нь жижиг буюу 80.36 % нь 0.5-1 мм хэмжээний мөхлөгүүдтэй,
мөхлөгүүдийн ихэнхи буюу 65-74 % нь муу мөлгөрсөн хумхиа хэлбэртэй байжээ.

Туршилтаар элсний угаагдах шинж чанарын итгэлцүүр E=0.3 байгаа нь хялбар
угаагдах чанартай гэж тогтоогдсон ба элсийг 20 мм ангиллаар скрубберээр задлан
шлюзээр, шлюзийн баяжмалыг тунаах машинд оруулах, тунаах машины торон дээрх
баяжмалыг нь ширээгээр баяжуулахыг санал болгосон байдаг. Алтны сорьцыг 881.1 гэж
тогтоожээ.

7. Зохиогчид Цагаан гозгорын алтны шороон ордын Жалга-4 хэсэг дэх хайгуулын
0-IX шугамуудын хоорондох эртний гольдролын геологийн нөөцийг бодитой В
зэрэглэлээр шлихээр 51.55 кг-аар, химийн цэврээр 45.11 кг-аар, боломжтой С зэрэглэлээр
шлихээр 33.56 кг-аар, химийн цэврээр 29.37 кг-аар, нийт бодитой болон боломжтой В+С
зэрэглэлээр шлихээр 85.11 кг-аар, цэврээр 74.48 кг-аар тус тус тооцжээ.

Шинжээч дээрх нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж ордын алтны
нөөцийг тооцоолж, зохиогчийн хувилбараар хүлээж авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн
хуралдааны үед Зөвлөлийн гишүүдийн олонхын саналын үндэслэл ордын нөөцийг
зохиогчийн хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо
бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзсэн байна.

8. Зохиогчид нөөцийн тооцоонд дараах жишигийн үзүүлэлтүүдийг авч хэрэглэсэн
байна. Үүнд:





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 03

№ ХХ - 09 - 08

Улаанбаатар хот

*Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших
Цагаан гозгорын алтны шороон ордын Жалга-4 хэсэг дэх
хайгуулын 0-IX шугамуудын хоорондох эртний
гольдролд 2021 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын
үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай*

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших Цагаан гозгорын алтны шороон ордын Жалга-4 хэсэг дэх хайгуулын 0-IX шугамуудын хоорондох эртний гольдролд 2021 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгээр геологич С.Мөнхбадрах, Д.Ганбат нарын боловсруулсан тайлан, уг тайланд дахь ордын нөөцийн тооцоонд МУ-ын зөвлөх геологич Б.Жаргалсайханы хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших 232 га талбай бүхий Цагаан гозгор нэртэй ашигт малтмалын MV-007978 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2007 оны 02 дугаар сарын 09-ний өдөр “Хурай” ХХК-д анх олгосон байна.

Тус талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 190 км-т, Төв аймгийн Цээл сумын төвөөс хойш 25 км, Хөтөл хотхоноос урагш 60 км, Орхонтуул сумаас зүүн урагш 40 км-т тус тус оршино.

2. “Хурай” ХХК нь тусгай зөвшөөрлийн талбайд 2021 онд геологи, хайгуулын ажлыг гүйцэтгэж, алтны шороон ордын геологийн нөөцийг бодитой болон боломжтой зэрэглэлээр тогтоож, хайгуулын ажилд нийт 350.5 сая төгрөг зарцуулсан байна.

3. Тус ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн өмнөд хэсэгт 1998–1999 онуудад хайгуулын ажлыг Ж.Тогтох, Т.Семейхан нар удирдан хийж, үр дүнгийн тайлан бичсэнээр C_1+C_2 зэрэглэлээр (баруун хэсэг 361.27 кг, зүүн хэсэг 78.22 кг) химийн цэврээр 439.49 кг алтны нөөц бүртгүүлсэн байдаг.

Түүнчлэн 2008–2009 онуудад геологч Ж.Баярхүү нар ашигт малтмалын MV-007978 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн Жалга-4 хэсэгт орчин үеийн гольдрол ба түүний доор байрлах Неогены улаан шаврын уланд орших эртний гольдролын хэмжээнд хайгуулын X-XIII дугаар шугам хооронд нөөц бодож, химийн цэврээр 42.21 кг алтны нөөц бүртгүүлэн олборлолт хийсэн байна.

“Хурай” ХХК нь дээрх тусгай зөвшөөрлийн талбайд 2007 оноос ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлж 2014 оныг дуустал хугацаанд явуулсан ба талбайн өмнөд хэсэгт 2000

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан алтны шороон ордын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Гурав. Энэхүү дүгнэлтийн 11-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Хурай” ХХК (Б.Биндэрьяа)-д анхааруулах.

Дөрөв. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч баримт, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан ҮГА-ны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Хурай” ХХК (Б.Биндэрьяа)-д даалгах.

Тав. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших Цагаан гозгорын алтны шороон ордын Жалга-4 хэсэг дэх хайгуулын 0-IX шугамуудын хоорондох эртний гольдролд 2021 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн боловсруулалтыг МУ-ын мэргэшсэн геологич С.Мөнхбадрах, Д.Ганбат нар. алтны сорьт болон шигшүүрийн шинжилгээг “Нөмөрт ээж майнинг” ХХК-ийн лаборатори, технологийн туршилтыг Геологийн төв лаборатори, байр зүйн зураглалын ажлыг “Трайминерал марк” ХХК тус тус хариуцах, дээрх гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг МУ-ын зөвлөх геологич Б.Жаргалсайхан, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Хурай” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛВАР ХУРАЛДААНЫГ
ДАРГА

Б.УЯНГА

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Б.Жаргалсайхан*

Б.БАЯРСАЙХАН